



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Ирээдүйн одод сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг  
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: [narmandakhts@audit.gov.mn](mailto:narmandakhts@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

“Төгс Нотолгоо аудит” ХХК-ийн захирал: Г.Цэцэгмаа  
Утас: 99889665 Цахим хаяг: [tugsnotolgooaudit@gmail.com](mailto:tugsnotolgooaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.23 № 37  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР  
СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙН  
ОДОД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.БАЯРМАГНАЙ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Ирээдүйн одод сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Ирээдүйн одод сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын Ирээдүйн одод сургуулийн 2023 оны үйл ажиллагааны зарцуулах баталсан төсөв, төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, төсвийг 17.8 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 82.1 хувьтай тайлагнаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 125,875.7 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 28.4 хувиар өсөж, төсвийн хуваарийг 9 удаа өөрчлөн, 2023 оны 12 дугаар сарын 25-нд сүүлийн хуваарийг баталж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг 96.0 хувьтай үнэлсэн байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 205 хүүхдээр тооцсон боловч 188 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>137,886,045.07</u></b>	<b><u>293,960,565.60</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	37,407,268.14	163,282,918.36
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	37,407,268.14	163,282,918.36
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	37,407,268.14	163,282,918.36
31211	Төрийн сангийн харилцах	37,407,268.14	163,282,918.36
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,365,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,365,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	3,365,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	97,113,776.93	130,677,647.24
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	72,779,497.13	106,689,009.74
35110	Тусгай зориулалттай материал	72,779,497.13	106,689,009.74
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,334,279.80	23,988,637.50
35410	Бичиг хэргийн материал	373,000.00	90,500.00
35420	Аж ахуйн материал	8,467,250.00	7,962,650.00
35430	Сэлбэг хэрэгсэл	15,350,029.80	15,935,487.50
35450	Барилгын засварын материал	144,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>892,360,406.71</u></b>	<b><u>1,673,671,991.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	892,360,406.71	1,673,671,991.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	802,822,906.59	1,578,008,990.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	806,147,236.52	1,562,082,678.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,343,088.96)	(99,634,784.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,000,000.00	8,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,000,000.00)	(8,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,184,462.00	129,963,622.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(33,826,833.92)	(47,940,582.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,165,428.93	56,360,628.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,504,297.98)	(22,822,571.57)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	89,537,500.12	95,663,000.15
39301	Програм хангамж	550,000.00	8,090,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(412,499.88)	(1,826,999.85)
39303	Бусад биет бус хөрөнгө	89,400,000.00	89,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,030,246,451.78</u></b>	<b><u>1,967,632,556.73</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,030,246,451.78</u></b>	<b><u>1,967,632,556.73</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,030,246,451.78	1,967,632,556.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,813,532.47	137,813,532.47
51101	Өмч: - төрийн	48,413,532.47	48,413,532.47
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	89,400,000.00	89,400,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	835,976,015.78	1,773,362,120.73
51210	Өмнөх үеийн үр дүн	835,976,015.78	835,976,015.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	937,386,104.95

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,456,903.53	56,456,903.53
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,030,246,451.78</b>	<b>1,967,632,556.73</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,670,342,297.79</b>	<b>1,734,129,178.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,006,655,397.79</b>	<b>835,176,378.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,006,655,397.79	835,176,378.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,635,100.00	1,000,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,460,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,000,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,175,100.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	884,821,455.23	803,850,602.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	97,198,842.56	30,325,576.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>663,686,900.00</b>	<b>898,952,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	611,246,300.00	863,015,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	611,246,300.00	863,015,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,440,600.00	35,937,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,440,600.00	35,937,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>635,894,544.08</b>	<b>796,233,768.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>635,894,544.08</b>	<b>796,233,768.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	632,343,334.08	786,775,642.96
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	497,589,161.00	617,111,477.96
210101	Үндсэн цалин	384,477,345.00	439,545,497.15
210102	Нэмэгдэл	96,124,269.00	156,739,792.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	845,600.00	1,694,362.38
210104	Урамшуулал	16,141,947.00	19,131,825.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,717,707.86	76,872,971.82
210201	Тэтгэврийн даатгал	42,340,908.70	52,464,857.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,981,240.05	6,171,971.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,985,252.09	4,937,758.63
210204	Ажилгүйдлийн даатгал	945,906.85	1,192,061.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9,464,400.17	12,106,322.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,590,113.00	19,461,574.69
210301	Гэрэл, цахилгаан	3,639,308.00	4,875,781.46
210302	Түлш, халаалт	11,116,358.00	9,925,853.72
210303	Цэвэр, бохир ус	3,834,447.00	4,659,939.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,565,900.00	5,711,656.39
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,565,900.00	526,050.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,185,606.39
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,994,953.70	-
210502	Хоол, хүнс	7,994,953.70	-

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	804,500.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	804,500.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,270,000.00	5,499,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,460,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	810,000.00	4,499,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,810,998.52	54,118,962.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,560,350.00	8,435,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,826,500.00	2,094,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,424,148.52	43,588,912.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,551,210.00	9,458,125.31
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,223,000.00	7,482,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,223,000.00	7,482,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,328,210.00	1,976,125.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,328,210.00	1,976,125.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,034,447,753.71</b>	<b>937,895,410.43</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	4,201,301.93	509,305.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,201,301.93	509,305.48
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(4,201,301.93)	(509,305.48)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,030,246,451.78</b>	<b>937,386,104.95</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>666,769,634.00</b>	<b>899,953,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,460,000.00</b>	<b>1,000,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,460,000.00	1,000,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,460,000.00	1,000,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,460,000.00	1,000,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>665,309,634.00</b>	<b>898,952,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	611,246,300.00	863,015,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	611,246,300.00	863,015,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	52,440,600.00	35,937,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,440,600.00	35,937,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,622,734.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,622,734.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>618,574,365.86</b>	<b>774,077,349.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>618,574,365.86</b>	<b>774,077,349.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>613,400,421.86</b>	<b>764,619,224.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	497,589,161.00	617,111,477.96
210101	Үндсэн цалин	384,477,345.00	439,545,497.15

210102	Нэмэгдэл	96,124,269.00	156,739,792.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	845,600.00	1,694,362.38
210104	Урамшуулал	16,141,947.00	19,131,825.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,717,707.86</b>	<b>76,872,971.82</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,340,908.70	52,464,857.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,981,240.05	6,171,971.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,985,252.09	4,937,758.63
210204	Ажилгүйдлийн даатгал	945,906.85	1,192,061.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9,464,400.17	12,106,322.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,590,113.00</b>	<b>19,461,574.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,639,308.00	4,875,781.46
210302	Түлш, халаалт	11,116,358.00	9,925,853.72
210303	Цэвэр, бохир ус	3,834,447.00	4,659,939.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,213,000.00</b>	<b>-</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,213,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,818,390.00</b>	<b>-</b>
210502	Хоол, хүнс	7,818,390.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>804,500.00</b>	<b>14,500,000.00</b>
210604	Урсгал засвар	804,500.00	14,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,635,000.00</b>	<b>2,914,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,460,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,175,000.00	1,914,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,032,550.00</b>	<b>33,759,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,419,350.00	29,401,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,613,200.00	4,358,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,173,944.00</b>	<b>9,458,125.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,845,734.00</b>	<b>7,482,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,622,734.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,223,000.00	7,482,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,328,210.00</b>	<b>1,976,125.31</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,328,210.00	1,976,125.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>48,195,268.14</u></b>	<b><u>125,875,650.22</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,788,000.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,788,000.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,788,000.00</b>	<b>-</b>
222001	Тоног төхөөрөмж	10,788,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(10,788,000.00)</u></b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>37,407,268.14</b>	<b>125,875,650.22</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>37,407,268.14</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>37,407,268.14</b>	<b>163,282,918.36</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	137,813,532.47	56,456,903.53	835,976,015.78	1,030,246,451.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>137,813,532.47</b>	<b>56,456,903.53</b>	<b>835,976,015.78</b>	1,030,246,451.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>137,813,532.47</b>	<b>56,456,903.53</b>	<b>835,976,015.78</b>	1,030,246,451.78
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>137,813,532.47</b>	<b>56,456,903.53</b>	<b>835,976,015.78</b>	1,030,246,451.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>137,813,532.47</b>	<b>56,456,903.53</b>	<b>835,976,015.78</b>	1,030,246,451.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			937,386,104.95	937,386,104.95
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>137,813,532.47</b>	<b>56,456,903.53</b>	<b>1,773,362,120.73</b>	1,967,632,556.73

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	932,998,800.00	772,101,224.47
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	932,998,800.00	772,101,224.47
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	906,463,300.00	764,619,224.47
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	727,166,900.00	617,111,477.96

210101	Үндсэн цалин	500,133,200.00	439,545,497.15
210102	Нэмэгдэл	205,204,200.00	156,739,792.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,829,500.00	1,694,362.38
210104	Урамшуулал	-	19,131,825.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	90,896,100.00	76,872,971.82
210201	Тэтгэврийн даатгал	61,809,400.00	52,464,857.51
210202	Тэтгэмжийн даатгал	7,271,700.00	6,171,971.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,817,300.00	4,937,758.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,454,300.00	1,192,061.90
210205	Эрүүл мэндийн даатгал	14,543,400.00	12,106,322.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,235,700.00	19,461,574.69
210301	Гэрэл, цахилгаан	6,200,900.00	4,875,781.46
210302	Түлш, халаалт	9,810,700.00	9,925,853.72
210303	Цэвэр, бохир ус	20,224,100.00	4,659,939.51
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,500,000.00	14,500,000.00
210604	Урсгал засвар	14,500,000.00	14,500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,614,500.00	2,914,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,614,500.00	1,914,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,050,100.00	33,759,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,692,000.00	29,401,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,358,100.00	4,358,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	26,535,500.00	7,482,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,535,500.00	7,482,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,535,500.00	7,482,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	913,750,800.00	898,952,800.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	863,015,100.00	863,015,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	863,015,100.00	863,015,100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	50,735,700.00	35,937,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	50,735,700.00	35,937,700.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>37,407,268.14</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>163,282,918.36</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт:** /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж/

Аудитаар нийт 5,185.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 5,185.6 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

**Залруулсан алдаа:**

- Тайланд онд акталсан 5,185.6 мянган төгрөгийн бараа материалыг тодруулга тайланд зарцуулснаар тайлагнасан нь УСНББОУС 1, 24 болон аудитын ангилал, үнэлгээ хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн тайланд залруулан алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар нийт 18,131.9 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 18,131.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

**Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

**Албан шаардлага**

Хөрөнгийн тооллогын бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн хөрөнгийн үлдэгдэлтэй тулгахад 2,917.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, сэлбэг хэрэгслийн эргэлтийн хөрөнгийн ангилалд 15,396.0 мянган төгрөгийн ном, сурах бичгийг бүртгэж, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

**5.1 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Ирээдүйн Одод сургууль	1	5,185.6					1	5,185.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,185.6</b>					<b>1</b>	<b>5,185.6</b>				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ирээдүйн Одод сургууль	1	2,917.3			1	2,917.3						
	1	15,395.6			1	15,395.6						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>18,312.9</b>			<b>2</b>	<b>18,312.9</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

---